

ХVШ ЗУУНЫ ЭХЭН ҮЕИЙН ЗҮҮН ГАР БУЮУ ГАЛДАНЦЭРЭН ХАН: ТОД БАРИЙН АЛТАН ҮЕ

Мянгад Эрдэмт

1662 онд тод үсгийг зохион үйлдсэн Равжамба Зая бандида Намхайжамц (цаашид Зая бандида гэж товчилно) таалал төгссөний дараа дөрвөн Ойрадын дотоодод самуун болж дайн дэгдсэн байна. Ялангуяа тухайн үеийн хоёр том хүчирхэг болох Хошууд Очирт цэцэн хан хийгээд Галдан бошготын хооронд болсон Зүүнгарын үнэнхүү эзэрхэх эрхийг булаалдсан дайн нь намжуун тогтуун байдлыг бүр мөсөн эвджээ. Түүнээс эхэлж Зүүнгарын дотоодод төдийгүй Зүүнгар хийгээд халх, Зүүнгар хийгээд Төвд, Зүүнгар хийгээд Чин улсын хооронд ч зөрчил тэмцэл хурцдан ширүүсэв. Нийгмийн тогтуун бус байдал нь тод үсгийн судар номын үйлсийн хөгжилд ашиггүй байдлыг бий болгосон нь мэдээж.

Зая бандида таалал төгссөн гэдэг боловч түүний шавь нар Зүүнгарын шашин ба соёлын төв болсон Ойрадын Их Хүрээгээ сахин хамгаалж, шашин номын үйлсэд зүтгэсээр байв. Гэтэл голцуу хошуудыг түшиж байсан Их Хүрээг Галдан хан өөрөөс нь холдохоос сэжиглэсээр байлаа. Тийнхүү Галданы доорхи хүмүүс Их Хүрээний лам нарт удаа дараалан хөнөөл учруулж, лам нарыг хардан яллах, эд хогшлыг булаах зэрэг ажлыг ер зогсоогүй хийсээр байж билээ. Ялангуяа 1688 онд Галдан хан зүүншээ халхыг дайлахад Их Хүрээнээс долоон зуу гаруй ламыг цэрэгт татсан байжээ. Иймэрхүү ашиггүй байдал доор 17-р зууны сүүлч болоход тод үсгийн голомт, нэгэн үеийн ойрадын шашин номын төв асан Их Хүрээ таран алга болжээ. Тийнхүү 17-р зууны сүүлчээс 18-р зууны эх буюу Галданцэрэн хан (1695-1745)-ы үе хүртэлх бараг хагас зууны хугацаанд Зүүнгарын нутагт тод үсгийн ном судрын түүх лугаа холбогдох тодорхой баримт мэдээнүүд огт олдохгүй байна.

Авхаалж сайтай Галданцэрэн бээр хан сууринд суусны дараа Зүүнгар үргэлжлэн хүчирхэгжсэн төдийгүй, тэрбээр Ойрадын соёлын бүтээн байгуулалтыг ихэд хүндэтгэсэн ба түүний нэг тодорхой жишээ нь тод үсгийн судар номын үйлсийг бадруулан хөгжүүлсэн ажил болох юм. Тийнхүү Галданцэрэн хааны үе бол Ойрадын тод үсгийн сурвалж бичгийн хөгжилтийн чухал шат үеийн нэг мөн. Ялангуяа тод үсгийн барийн номын эхлэл мөртлөө оргил үе гэж хэлж болно.

Галдан бошгот хан халхыг довтолж, дахин цаашид Чин улстай дайтаж байсан хойгуур түүний ач хөвүүн Цэвээнравдан бээр Ховдоос гаднах Зүүнгарын ихэнх нутгийг эзлэн авчээ. Ялангуяа 1697 онд Галдан бошгот хан Манжид ялагдан, Ац Амтайд нас барсны дараа Зүүнгарын үнэнхүү эзэрхэх эрх цөм Цэвээнравданы гарт оров. Гэтэл 1723 онд Цэвээнравдан ханы авааль хатан нас барсан ба тухайн үед хааны бие ч сайн биш байдлыг далимдуулан торгууд хатан Сэтэржав өөрийн хөвүүн Лувсансоно лугаа далдуур сүлбээлж хан орныг булаахаар хуйвалдаж байжээ. Нэн харамсалтай нь 1727 онд Сэтэржав хатнаар Цэвээнравдан хаанд хор өгч хорлож

алсан төдийгүй залган хунтайжийн залгамжлагч болох Цэвээнравдан ханы ууган хөвүүн Галданцэрэнийг ч хорлохоор бэлтгэж байв. Галданцэрэн тэрхүү ордны дотоодод болох гэж байгаа уг явуулгыг сэрж мэдсэн ба туйлбартай дарангуйлал хийж хунтайжийн сууринд гарав. Галданцэрэн хан сууринд гарсны дараа идэвхтэй арга хэмжээ авч өөрчлөлт хийв. Түүний эрх барьж байсан хугацаанд Зүүнгарын аж ахуй үтэр түргэн хөгжсөн төдийгүй, цэрэг дайны хувьд ч улам хүчирхэгжив.

1727 онд Галданцэрэн хан болсноо Чин улсад мэдэгдэв. Гэтэл Чин улс Зүүнгарыг мөхөөх тохитой завшаан хэмээн 1729 онд цэрэг гаргаж хоёр замаар Зүүнгарыг дайлсан боловч ялагдав. 1730-1732 оны хооронд Зүүнгарын цэрэг Чин улсын цэргийг ихээр алж сөнөөсөн төдийгүй Чин улстай дайтаж ялалт олсон Галданцэрэн хан дахин халхыг эрхэндээ оруулж авахаар төлөвлөж байсан боловч биелэгдсэнгүй.

1745 онд Илийн газарт цэцэг өвчин дэлгэрч, олон хүн хижигт нэрвэгдсэн ба Галданцэрэн хаан ч тэр шалтгаанаар нас баржээ. Галданцэрэн бол Ойрадын түүх төдийгүй Төв Азийн түүхэн дээрх алдарт улс төрч төдийгүй ойрадын соёлын түүхэнд маш чухал үүрэг гүйцэтгэсэн хан буюу. Галданцэрэн ханы Ойрадын соёлын түүхэнд үзүүлсэн томоохон зүтгэлийн нэг нь судар номыг дуртган орчуулуулах буюу ариутган шүүж хэвд сийлэн барлуулсан зэрэг ажлууд болох юм.

1975 онд Монгол улсын эрдэмтэн Х.Лувсанбалдан “Тод үсэг, түүний дурсгалууд” гэдэг номондоо тусгайлан тод үсгийн барын номын тухай судлан танилцуулсан ба ялангуяа Монгол улсын Хэл зохиолын хүрээлэнгийн тод үсгийн хөмрөгт хадгалж байгаа Галданцэрэн ханы үеийн хэд хэдэн модон барыг нэлээд системтэй шинжилсэн билээ (Лувсанбалдан, 1975:112-122). 18-р зууны өмнө хагаст холбогдох тод үсгийн судар номын тухай судалгаа түүнээс хойш сайн явагдаагүй. Х.Лувсанбалданы судалгааны суурин дээр миний бие “Дундад улсад хадгалагдаж байгаа тод үсгийн барын номын тухай”, “Дундад улсад хадгалагдаж байгаа тод үсгийн барын номын тухай дахин өгүүлэх нь (1742-1949)” (Мянгат Эрдэмт, 2009, 2011) зэрэг өгүүлэл нийтлүүлж Дундад улсад хадгалагдаж байгаа тод үсгийн барын номын тухай анхааран судалсныг гаргавал энэхүү цаг үед холбогдох тод үсгийн судар номын үйлс тууштай сайн судлагдаагүй байсаар гэж хэлж болно.

18-р зууны өмнө хагаст холбогдох тод үсгийн судар номын тухай судалгаа ахиж чадаагүйн чухал шалтгаан нь шинэ материал хомс байгаагаас болсон юм. Дайн дажин зэрэг элдэв шалтгаанаар тэр цаг үеийн ховор дурсгалуудын олонх нь үрэгдэн сүйдсэн бололтой. Харин азаар ойрын жилүүдэд зохиогч бээр Илийн голын урсгал дагуу оронд хээрийн шинжилгээ хийх явцад тус сэдэв лугаа холбогдох чухал чухал шинэ материалыг илрүүлсэн бөгөөд тус асуудлын тухай дахин нарийвчлах боломжтой болжээ.

Дор 1731 онд Галданцэрэн ханы зарлигаар орчуулсан анагаах ухааны зохионгуй, 1741-1742 онд Галданцэрэн ханы зарлигаар шүүн ариутгаж, барласан судар ном, 1744 онд Галданцэрэн ханы зарлигаар дахин орчуулж барласан судар, Содномдулам хатны зарлигаар шүүн ариутган хэвлүүлсэн “Хутагт дарь эхийн хорин нэгэн магтаал хэмээх оршив” зэрэг дөрвөн талаар 18-р зууны өмнө хагаст холбогдох Зүүнгарын тод үсгийн судар номын үйлсийн тухай өгүүлэх болно.

1. 1731 он: Галданцэрэн ханы зарлигаар орчуулсан анагаах ухааны зохионгуй

Бурхан шашны судар номын үйлсийн чухал агуулгийн нэг нь дуртган орчуулах юм. Өглөгийн эзэд, сүсэгтэн нар үнэн сүсгээр элдэв буяны төлөө лам хувраг нарт шүтэн, бурхны ном судрыг орчуулахыг хүсдэг. Түүнд бурхан шашны их хөлгөн судрууд байдаг бөгөөд бас үйрмэг жижиг судрууд ч байдаг. Мөн бурхны шашин лугаа холбогдол бүхий анагаах ухааны болон түүхийн зохионгуй зэрэг бусад төрлийн ном судар ч багталцдаг буюу. Монгол бурхан шашны орчуулгын судар номын нэлээдгүй нь иймэрхүү тохиолдолд буй болж бүрэлддэг. Түүнд хаан хатан, ноёд түшмэл, эгэл ард, лам хувраг зэрэг нийгмийн эл этгээдийн бүх давхаргын хүмүүс цөм багталцдаг. Монголын бурхан шашныг тэтгэсэн эл үеийн хаад тиймэрхүү ажлыг гүйцэтгэж байсан юм. 1628-1629 оны хооронд Умард Юань улсын үеийн сүүлчийн хаан Лигдэн хутагтын дуртгал буюу зарлигаар бүтээсэн алтан бичмэл “Ганжуур” бол түүнийг төлөөлөх бүтээл мөн. Төр шашныг хослуулан барьж байсан хаад ноёдын хувьд тэр нь шашин төрийг бататган, ард иргэдийг амаржуулах чухал аргын нэг ч мөн буюу. Хаан хатан бол төр шашны жолоог барьж байгаа хамаг том өглөгийн эзэн болохоор тэдгээр хэлмэрч гүүш нар залбиран гүйцэтгэж “зарлигаар” гэж төгсгөлийн үгэндээ зүй ёсоор тэмдэглэдэг. Харин бусад хүмүүсийг бол “дуртгагч, дуртган, дурдсан” хэмээн зүйл зүйлээр өгүүлдэг.

Галданцэрэн ханы үед чухам шашин номыг хэр тэтгэж байсан бэ гэдэг нарийн зүйлс тодорхой мэдэгдэхгүй боловч одоо олдсон шинэ материалд тулгуурлавал түүний тод үсгийн судар номын үйлсийг тэтгэж явсан судас их төлөв харагдаж буй.

Галданцэрэн ханы үед тэрбээр ямар ямар судар номуудыг дуртган орчуулуулж байсан бэ? гэдгийг одоо мэдэх аргагүй. Азаар 2004 оны зуны хээрийн шинжилгээний дүнд Шинжааны Илийн Хасаг үндэстний өөртөө засах жоугийн Монголхүрээ сяний Сайхантохойн тариачин, ном нээдэг багш Ринчен Нипагийн хадгаламжид буй Галданцэрэн ханы өөрийн биеэр дуртган орчуулуулсан “Увидас эрдмийн үндэсний халууны энэлэг арилгахуй хадбур цаг бусын үхлийн цалам таслах илд оршив”-ийн тодчилгыг олж мэдсэн билээ. 2015 оны зуны байцаалтад мөн зохионгуйн бүтэн зургийг авсан ба цаашид судлах боломжтой болов.

Уг судар бол 1690-1691 оны хооронд V Далай ламын дэргэд агсан төвд хүн Дисрид Санжаажамц (1653-1705)-ийн зохиосон анагаах ухааны бүтээл юм. Энэхүү зохионгуйн нөгөө нэр нь “Лхантав” гэдэг ба он тооллын 8-р зуунд зохиогдсон “Анагаах ухааны дөрвөн үндэс”-ийн дараах Төвдийн анагаах ухааны шинэ амжилтыг төлөөлөгч аварга бүтээл хэмээн үнэлдэг. “Лхантав” зөвхөн Монгол оронд орчуулагдсан төдийгүй Монгол анагаах ухаанд маш их нөлөө өгсөн тухай эрдэмтэд үнэлэн ярилцсаар.

Тод үсгийн “Лхантав” тийм олон үлдэж ирсэнгүй. Эдүгээ мэдэгдэж байгаагаар Өвөр Монголын Их сургуулийн номын сан ба Шинжаан Уйгурын Өөртөө засах орны үндэстний эртий ном бичгийг эмхэтгэх албан гэрийн монгол ном бичгийн тасагт тус тус нэг хувь бичмэл эх хадгалагдаж буй.

Ринчен Нипагийн хадгаламжид байгаа “Увидас эрдмийн үндэсний халууны энэлэг арилгахуй хадбур цаг бусын үхлийн цалам таслах илд оршив” бол судар хэлбэртэй, бэх шунх алагласан хулсан үзэгийн бичмэл, 11х50 см, 266 хуудас, хуудасны хоёр талд бичсэн болохоор нийт 532 нүүр. Уг судар ихэд эвдрэн сүйдсэн ба цаасаар наан зассан ором ил. Тус судрын төгсгөл үгэнд дуртгагч, орчуулагч, орчуулсан цаг зэргийг тодорхой тэмдэглэж буй. Төгсгөлийн үгийг сийрүүлбэл:

«arašāni jüreken nayiman gešöütü niyüča ubadis erde/miyin ündüsüni xalalta xadxulxui xalouni enel/ge arilyaxui ka bur čaq busuyin üküliyin čalma tasula/xui yildü kemēkü ööni šajini öqliküyin/ejen dgā ldan ze ring dwang_pü tani jarliyār / emči blo_bčang_rnam_rgel bolöd olon sayin emči / ner tei nagq_pa dge_jol jui_bzang_po tömür / yaxai jil-dü kürböülbe / sarwa ma gi le»¹.

Дээрх төгсгөл үгээс доорх мэт зүйлсийг мэдэж болно.

1. Уг судрыг дуртган орчуулуулсан хүн бол шашны эзэн Галданцэрэн хан,
2. Орчуулагч бол эмч Лувсаннамжил болон олон сайн эмч нэртэй агва гэцэл Чойсамбуу
3. Орчуулсан жил нь төмөр гахай жил.

Төгсгөл үгээс тодорхой болсон зүйлс гэвэл энэхүү судрыг орчуулах тухай зарлиг буулгасан хүн бол шашны өглөгийн эзэн Галданцэрэн хан. Уг судрыг орчуулсан хүн бол эмч Лувсаннамжил болон олон Сайн эмч нэртэй агва гэцэл Чойсамбуу болох ажээ. Нөгөө орчуулсан он жил ч төмөр гахай жил болохыг тэмдэглэсэн байна.

Галданцэрэн ханы үе буюу түүний хан оронд байсан 1727-1745 оны хооронд төмөр гахай жил ганц удаа тохиолдоно. Тэр нь 1731 он болох юм. Тийнхүү энэхүү анагаах ухааны зохионгуйг Галданцэрэн хан 1731 онд эмч Лувсаннамжил болон олон сайн эмч нэртэй агва гэцэл Чойсамбуу хоёрт зарлиг буулган орчуулуулсан байжээ.

“Рашааны зүрхэн найман гишүүт нууц увдис эрдмийн үндэсний халаалт хадгалахуй халууны энэлэг ариулахуй хадбур цаг бусын үхлийн цалам таслах илд” бол эдүгээ бидний гарт олдсон Галданцэрэн ханы үеийн тод үсгийн судар номын үйлс лүгээ холбогдсон хамаг эртний орчуулга мөн. Мөн ч эдүгээ бидний гарт олдсон бүхий л 18-р зууны үеийн хамаг эртний орчуулга болно. Тийнхүү Галданцэрэн ханы тод үсгийн судар номын үйлс наад зах нь түүний хан сууринд сууснаас дөрвөн жилийн дараа буюу 1731 онд нэгэнт эхэлсэн гэдгийг тус орчуулга гэрчилж буй.

Энэхүү зохионгуй олдсон нь 18-р зууны өмнө хагаст холбогдох тод үсгийн сурвалж бичгийн судалгаанд ховор нандин шинэ сүвэгчийг олгосон юм. Өнгөрсөнд бид Галданцэрэн хан буюу 18-р зууны үеийн тод үсгийн судар номын үйлсийг ярихад зөвхөн 1741-1742 оны хоёр жилд түүний зарлигаар шүүн ариутгаж барласан хэдхэн судраар жишээ болгодог байжээ. “Лхантав”-ын тодчилгын олдсон Галданцэрэн ханы үеийн тод үсгийн судар номын үйлс зөвхөн шүүн ариутгаж барлах төдий биш бас орчуулга байсан гэдгийг батлах чухал мэдээг бидэнд хангасан байна. Түүнчлэн Галданцэрэн ханы үеийн судар номын үйлсийн агуулгыг улам баялаг болгожээ. Мөн тухайн үеийн тод үсгийн судар номын үйлсийн эхлэлтийн цэгийг тогтоох чухал сэжмийг хангасан байна.

“Лхантав”-ын тодчилгоос харахад нэгэнт тасарсан Зүүнгарын тод үсгийн судар номын орчуулгын үйлс 1731 он буюу 18-р зууны гучаад оны үед эхлэн сэргэсэн гэж үзэж болно.

2. 1741-1742 он: Галданцэрэн ханы зарлигаар шүүн ариутгаж барласан судар ном

Зүүнгарын хан асан Галданцэрэн ханы тод үсгийн бурхан шашны судар номын үйлсэд үзүүлсэн хамгийн том амжилт нь шүүн ариутгаж, хэвд сийрүүлсэн модон барууд юм. Тийм мөртөө тэр нь зөвхөн Галданцэрэн ханы хувь хүний аугаа үйлс төдий биш, бүхий л тод үсгийн сурвалж жич Ойрдын соёлын түүхэнд заавал тэмдэглэх ёстой гавъяа зүтгэл мөн. Эдгээр модон барын тухай Х.Лувсанбалдан “Тод үсэг, жич түүний дурсгалууд” номондоо анх танилцуулсан

¹ Увидас эрдмийн үндэсний халууны энэлэг ариулахуй хадбур цаг бусын үхлийн цалам таслах илд оршив. Бэх шунх алагласан хулсан үзгийн бичмэл. 11х50 см. 166б. Ринчен Нипагийн хадгаламжид буй.

юм (Лувсанбалдан, 1975:112-122). Тус өгүүлэлд Х.Лувсанбалданы судалгаанд суурилж цаашид Зүүнгар буюу тод үсгийн түүхэн дээрх шүүж ариутгасан бурхан шашны судар номын үйлсийн тухай улам тодруулан өгүүлэх болно. Одоогоор олдоод байгаа Галданцэрэн ханы үед шүүн ариутгаж хэвлүүлсэн модон барын судар номоос доорх мэт зүйлс олдож буй.

1. “Хутагт судрын аймгийн эрхт хаан дээд Алтангэрэл хэмээх их хөлгөний судар”

Энэхүү ховор нандин модон бар хэвлэгдсэн мэдээ буй авч уг эх нь олдоогүй. Харин модон бараас хуулсан га бичмэлүүд нь хэд хэд олдоод буй. Уг судрын төгсгөлийн үгэнд

«ene altan gereliyin suduri urida rab_žam_pa xutuqtuyin gegēn körböüleqsen-ēce jabsartu bičiēci terigūteni erkēr üleqsen tasuraqsan endöüreqsen бүгүдеи-гi šaryin šajini öqligüyin ejen dgā_ldan_zhereng wangpo jarliγār sakns_pa dke_slong bzangpu_ržmzo tus bsam_gling dge_slong bkraši_ržl_mzha dge_slong jüing_drüing_dar_ržs dge_slong lhün_grub_ržamzo maši ariun eke bičigüdtü tulγan šüji ariudyād tömör takā jildü mongγol-yēr kebtü daroulbai. öün-yēr ilayūqsani šajin erdeniyin γadar dotori-yin хаγацахуйин siltāni kir бүкүн arilun jūq čaq бүкүндү örgüjin delgereji öni udān orošixu boltuγai» (Лувсанбалдан, 1975:116) гэжээ.

Тус төгсгөлийн үгэнд доорх мэт мэдээнүүд багтаж буй.

1. Уг судар бол “Алтангэрэл”,
2. Уг судрыг анх Зая бандида орчуулсан,
3. Уг сударт бичээч тэргүүтний эндүүрэл буйг Галданцэрэн ханы зарлигаар сангасваа гэлэн Самбуужамц, тойсамлин гэлэн Раашжалцан, гэлэн Юнрэндаржаа, жай гэлэн Лхүнрэвжамц нараар бусад бичгүүдтэй тулгаж шүүн ариутгасан байна.
4. Төмөр тахиа жил буюу 1741 онд хэвд сийлж бүтээжээ (Лувсанбалдан, 1975:116).

“Алтангэрэл”-ийн төгсгөлд бас:

«arši dēdū šāžamoniyin sedkiliyin šime ali šütüqsen xubitani erel sayitur xangγaqči ašida angxurun abxulā хойор siddhi ögüqči ariun sayin jarligyin ogi altan gerel öüni ertenі buyan-yēr oloni ejen beye olun engkereküi sūjūq-yēr erdeni γurban kigēd blam šajini takiqči endöürel ügei uxān-yēr arγa biliq бүтэн burxani kereqleqči enereküi sedkil tögüsūqsen axalai aldar duraduqsan-du olon xobitai ortoγui niswāniši darun osoldol ügei tonilxui möriyin šatu baiγūlun olburi dēdū yeke amuyoulanggi olxuyin tula oqtorγuyin dalai rab_žam ča_ya pandida orčiulbai onomγoi uxātu mergen gūši čhülkirim_ržamčho samurdan ončo dēdūgi kereqleqči ketürkei bičiēci dge_gdun_bčangpu čāsun-du bičiqsen olburi buyani ауγа-bēr törö šajin örgüjin delgereji olon törölkitön ončo nom-yēr yabuji burxan boltuγai sarwa ma gha le»² гэдэг тэмдэглэл байдаг.

Түүнчлэн «Алтангэрэл» судрыг Зая бандида бээр ахлан Алдар тэргүүтний дурдлагаар орчуулсан билээ. Түүнийг гүүш Чүлтэмжамц үнсэн самбарт бичсэн ба Гэндэнсамбуу цаасанд буулган бичжээ. Уг судрыг Галданцэрэн ханы зарлигаар дахин ариутган шүүснээр барахгүй 1741 онд модон бараар барласан байна.

2. “Хутагт билгийн чинад хүрсэн туслагч очир хэмээх их хөлгөний судар”

Энэхүү ховор нандин модон барыг эдүгээ Монгол улсын Хэл зохиолын хүрээлэнгийн тод үсгийн хөмрөгт хадгалж буй. 13х33.5 см, 26 хуудас. Уг судрын төгсгөлд

«ene tasuluqči očiriyin suduri rab_žam_pa xutuqtuyin gegēn körböüleqsen-ēce jabsartu bičiēci terigūteni erkēr üleqsen tasuraqsan бүгүдеийгi šaryin šajini öqligüyin ejen dga_ldan_zhereng wangpo jarliγār sakns_pa dke_slong bzangpu_ržmzo tus bsam_gling dge_slong bkraši_ržl_mzha dge_slong

² Алтангэрэл. Бэх шунх алагласан бичмэл. 13х48 см. 78 хуудас (хуудасны 2 тал). Шинжааны Илиийн Хасаг үндэстний өөртөө засах жэүгийн Монголхүрээ саянийн Шат киргиз үндэстний сумын адууч Түнэр (1955-)-ийн хадгаламжид буй. 77б-78а.

jüng_drüng_dar_džs dge_slong lhün_grub_ržamzo tayilbur kigēd maši ariun eke bičigūdtü tulyan šüji ariudyād tömör takhā jildü mongyol-yēr kebtü daroulbai öün-yēr yilaquqsani šajin erdeniyin yadar dotoriyin хаяахууын siltān kir бүкүн арилун чуq цаq бүкүн örgüjin delgereji öni udān orošixu boltuγai» (Лувсанбалдан, 1975:118) гэжээ.

Тус төгсгөлийн үгэнд доорх мэт мэдээнүүд багтаж буй.

1. Орчуулсан судар бол “Таслагч очир”
2. Энэхүү судрыг Зая бандида орчуулсан.
3. Уг сударт бичээч тэргүүтний эндүүрэл буйг Галданцэрэн ханы зарлигаар сангасва гэлэн Самбуужамц, тойзамлин гэлэн Раашжамц, гэлэн Юнрэндаржаа, гэлэн Лүнрэвжамц нараар “Таслагч очирын тайлбар” ба бусад эх бичгүүдтэй тулган шүүж ариутгасан байна.
4. Төмөр тахиа жил буюу 1741 онд хэвд сийлж бүтээжээ (Лувсанбалдан, 1975:118).

Мөн судрын төгсгөлд бас «arši šažamuniyin jarliq biliq barimidiyin sudur ali šütuqseni tödüi ken-yēr aγa biliq tögüsken ayūs tamu terigūten orčilonggiyin kürdü tasuluqči očir öüni ariun sūjūqtü dare eke terigūlen oloni duraduqsandu rab_žam ča_ya pandida orčiuluqsan buyan-yēr ene orun-ēče terigū=len xamuq yertünčü-dü erdeni šajin ariun todorxoi del=gerēd eke boluqsan amitan ötör burxan bolxu boltuγai sarwa ma gha la»³ гэж тэмдэглэж байгаагаас үзэхэд “Таслагч очир”-ын судрыг Зая бандида бээр Дарь эх тэргүүтний дурдлагаар орчуулжээ. Энэ судрыг Галданцэрэн ханы зарлигаар дахин ариутган шүүснээр барахгүй 1741 онд модон бараар барласан байна.

“Хутагт судрын аймгийн эрхт хаан дээд Алтангэрэл хэмээх их хөлгөний судар” ба “Хутагт билгийн чинад хүрсэн Таслагч очир хэмээх их хөлгөний судар” бол цөм Зая бандидын орчуулга мөн бөгөөд адилхан цагт барлагдсан байжээ. Энэхүү хоёр судар бол бидэнд мэдэгдээд байгаа тод үсэг буюу Ойрадын түүхэн дэх анхны модон бар мөртөөн хамаг эртний шүүн ариутгаж хэвлүүлсэн судар мөн. Мөн ч тод үсэг бол Ойрадын модон бар ба бурхан шашны судар номын шүүж ариутган хэвлүүлэх ажлын эхлэлт мөн буюу.

3. “Найман мянгат оршив”

Энэхүү ховор нандин барыг эдүгээ Монгол улсын Хэл зохиолын хүрээлэнгийн тод үсгийн хөмрөгт 2 хувь, Шинжааны Илийн Хасаг үндэстний өөртөө засах жэүгийн Монголхүрээ сянийн Монголхүрээ балгасны Хугай Бүрэнтөгс 1 хувь хадгалж буй. 10.9х42.7 см, 382 хуудас. Уг судрын төгсгөл үгэнд:

«ene nayiman mingyatuyin suduri urida rab_žam_pa xutuqtuyin gegēn körböölүqsen-ēče jabsar-tu bičieči terigūteni erkēr üleqsen tasuraqsan endöüreqsen бүгүдеyigi šarayin šajini öqligüyin ejen dgā_ldan_zhereng wangpo_tani jarliγār sakns_pa dke_slong bzangpu_ržmzo tus_bsam_gling dge_slong bkraši_ržl_mzha dge_slong jüנג_drүнг_dar_džs dge_slong lhün_grub_ržamzo nayiman mingyatuyin yeke taiyilburi kigēd ariun eke bičigūd-tü tulyan olon merged-ēče asaqji sögүгēd usun noxoi jildü mongyol-yēr kebtü daroulbai»⁴.

Тус төгсгөлийн үгэнд доорх мэт мэдээнүүд багтаж буй.

1. Уг судар бол “Найман мянгат”,
2. Уг судрыг Равжамба хутагтын гэгээн буюу Зая бандида орчуулсан,
3. Уг сударт бичээч тэргүүтний эндүүрэл буйг Галданцэрэн ханы зарлигаар ламрим гэлэн Агваанжамъян, сангасва гэлэн Самбуужамц, тойзамлин гэлэн Раашжалцан,

³ Таслагч очир. Хулсан үзэг. Бэх шунх алагласан. 8.5х48 см. 23а хуудас (хуудасны хоёр тал). Шинжааны Илийн Хасаг үндэстний өөртөө засах жэүгийн Монголхүрээ сянийн Цагаан хонины талбайн гэгцэл Баянбатын хадгаламжид буй. 23а.

⁴ Найман мянгат. Модон бар. 10.9х42.7 см. 382 хуудас (хуудасны хоёр тал). Шинжааны Илийн Хасаг үндэстний өөртөө засах жэүгийн Монголхүрээ сянийн Хугай Бүрэнтөгсийн хадгаламжид буй.

гэлэн Лүнрэвжамц, Юнрэндаржаа нараар “Найман мянгатын их тайлбар” ба бусад бичгүүдтэй тулгахын зэрэг олон мэргэдээс асууж суран шүүн ариутгасан байна.

4. Усан нохой жил буюу 1742 онд хэвд сийлж бүтээжээ (Лувсанбалдан, 1975:114).

“Найман мянгат оршив” гар бичмэл судрын төгсгөлд:

«nayiman tümen nomiyn öüde sayitur nēqči tül=kiür nayouda tōtoi erdem kigēd diyān-du oroxui öüden nayidangyui terigūten niswānišiyin ebeči arilyaqči dēdū em narmai yurban törölkitōni erel xangyaqči jandamani erdeni mani baqši yilayun tögūsūqsen šāžamoniyn jarliq manduxui naran metü gegigūleqči yol suduriyin xān mayad udxa arya biliq üjūlūqči nayiman mingyan šülüqtü mangnai uran arya tododxoxui biliq baramidiyin sudur öüni arban buyan öüride xurāqsan-yēr čolitu učirliyin sayin šütēni olon ašida dēdū xutuq kereqlen arya bili-giyin nom бүтēqči abutida dēdū yurban erdenigi takiqči giškib kigēd angkud=xui ügei sūjūq-tü čewang čecen tayiji terigūten duraduqsan-du toyin rab_žam za_ya pandida nayirolun orčiulbai todorxui uxātu radna_bhadra tong yaqčār samuradan tonilxui kereqleqči ketürkei bičēči dge_gdün_bjangpu čāsun-du bičin dousuqsan burxani kereqleqči dge_slong čos_ržamčho demnen bičibei ene metü buyan-yēr ene sudur xamuq-tu delgeren ene jügiyin amitan tonilxui möriyin xaryui-du oron endöürel ügei uxatan örgüjin arya bilig bisilyaxui erken ayanista terigūten sayin oron-du dēdū xutuq olxu boltuyai»⁵.

Энэхүү гар бичмэлийн төгсгөлийн үгээс үзэхэд “Найман мянгат оршив” судрыг Гишхив хийгээд Цэвээн цэцэн тайж тэргүүтэн дурдсанд Зая бандида орчуулсан ба үнсэн самбарт Раднаабадраа гагцаар бичжээ. Үнсэн самбарт бичсэн Раднаабадраа бол Зая бандидын үнэнч шавийн нэг бөгөөд түүний намтар “Сарны гэрэл”-ийг туурвигч мөн. Цаасанд буулган бичсэн Гэндэнсамбуу хийгээд Чүлтэмжамц хоёр буюу.

Орчуулахыг дуртгагч Гишхив хийгээд Цэвээн цэцэн тайж нар бол Дөрвөдийн ноён Далай тайшийн дөрөвдүгээр хөвүүн болох Омбо дайчин хошуучийн хөвүүн мөн. Омбо дайчин хошуучийн ууган хөвүүн Гишхив, хоёрдугаар нь Цагаан, гуравдугаар нь Цэцэн тайж юм. “Сарны гэрэл”-д энэ гурван хөвүүн Зая бандида ба Их хүрээг залсан тухай тэмдэглэл буй.

“Радэн номын хаан Равжамба цорж хэмээх цагт их эд мал олж баруун тал явахдаа Нуурын Хорголжинд учирч хөлгөнд нь жороо хээр, аргамаг хээр хэмээх хоёр морь өргөж авшиг аван найр үйлдэж, дээш өөд болов. Хүрээг ч Гишхив, Цагаан, Цэцэн тайж гурван хөвүүд залж Утуг Мунцуг хэмээхүйд (1655) өвөлжив. Цагаан сарын ерөөл дэлгэрэнгүй үйлдэн, Боди мөр, Бүчой тэргүүтнийг номлон цагаан буяны үйл дэлгэрэнгүй үйлдсэнд, тэд ч сүжиглэн хүндлэхийг агуу их үйлдэн өөд болохуй цагт гучин тэмээ, гурван зуун агтуудыг өргөв” (Зая бандида, 1999:116).

1654 онд торгууд Дайчин Зая бандида ба Хүрээг Ижил, Зайд залсан ба тэнд очих замдаа 1655 онд Уту Мунцугт Дөрвөдийн Хэсхив, Цагаан, Цэцэн тайж гурван хүүхэд залж, тэднийд өвөлжин ном буян ихээр хийсэн ажээ. Түүнээс өчихөд «Найман мянгат оршив»-ыг Зая бандида 1655 онд Утуг Мунцуг байхад эхлэн орчуулсан байж болох юм.

“Зарлигаар тогтоосон баруун хязгаарын газрын нэрсийг олон хэлээр тэмдэглэсэн бичиг”-ийг үндэслэвэл Омбо дайчин хошуучийн ууган хөвгүүн Чишхив, хоёрдугаар нь Чагун, гуравдах нь Цэцэн буюу (钦定西域同文志, 2005:174). Энэхүү тэмдэглэлээс үзэхэд зөвхөн бичлэгийн зөрүүтэйгээс биш дуртгагч гурван хүн дөрвөдийн Омбо дайчин хошуучийн хөвүүд болох нь нэн тодорхой. Омбо дайчин хошууч бол Дөрвөд Далай тайшийн хөвүүн мөн. Тэр 1640 оны “Их цааз” тогтооход оролцсон чухал хүний нэг мөн бөгөөд “Сарны гэрэл”-ий үндэслэвэл 1643 онд суварга амилуулахын төлөө Зая

⁵ Найман мянгат. Хулсан үзэг. Бэх шунх алагласан. 383 хуудас (хуудасны хоёр тал). Шинжааны Илиийн Хасаг үндэстний өөртөө засах жэүгийн Монголхүрээ сянгийн Төвжаргал Төрмөнхийн хадгаламжид буй. 382b-383a.

бандидыг урьж байсан ба ахуй их өргөл өргөсөн байдаг. Үүнээс үзэхэд Зая бандида Дөрвөдийн ноёдтой найр зузаан байсан гэдэг нь мэдэгдэж буй.

“Найман мянгат оршив”-ыг Галданцэрэн ханы үед буюу 1742 онд түүний зарлигаар ариутган шүүснээр барахгүй модон бараар хэвлэсэн байна. Энэхүү судрыг дээрх хоёр судар хэвлэгдсэний дараа жил нь шүүн ариутгаж хэвлэжээ. “Найман мянгат оршив” нийт 382 хуудас, 764 нүүр байж, эдүгээ бидний гарт олдсон тод үсгийн барын ном, бичмэл ном, жич ойрадуудын шүүн ариутгасан номуудын дотор хуудас хэмжээгээр хамгийн том нь юм.

Шүүж ариутгах гэдэг нь уг судар он цаг улиран ээлжлэх явцад эндүүрэл алдаш олон болохоос шалтгаалан бусад сайн эх буюу уг орчуулгын хэлний эхүүдтэй дахин тулган шүүж засаж ариутгах онцгой нарийн ажил юм. Эндүүрэл алдаш олон болохын чухал шалтгаан нь бичээч тэргүүтэн хуулах эсхүл хожмын хүмүүс барлах явцад буй болсон буруу үсэг, үсэг гээх, үсэг илүүдэх эсхүл буруу орчуулсан зэргийг заадаг. Бурхны номыг буруу эндүү дэлгэрүүлэх нь алдаш болохоор түүнийг ариутган шүүж хэвлэх нь шашин номын үйлсийн хувьд маш чухал ажил болох ажээ.

Зая бандида бол тод үсгийн бурханы ном судрын буй болж бүрэлдэхийн суурьлагч мөн. Тийнхүү дээрх гурван судрыг шүүж ариутгахад голдуу хожмын хүмүүсийн хуулах явцад гарсан эндүүрэл алдсыг засахаар гол зорилт болгожээ. Энэ тухай дээрх ном судрын төгсгөлд “Урьд Равжимба хутагтын гэгээн хөрвүүлснээс завсарт бичээч тэргүүтний эрхээр үлсэн тасарсан эндүүрсэн бүгдийг” гэж дуу нэгтэй хэлж байгаа болохоор Зая бандидын орчуулгыг ариутган шүүж байгаа биш, харин хожмын бичээч тэргүүтний эндүүрснийг шүүж ариутгаж байгаа гэдэг нь тодорхой байна.

3. 1744 он: Галданцэрэн ханы зарлигаар дахиж орчуулж барласан судар

“Шашинд орохын үүд итгэлийн хөтөлбөрийн сэтгэлгэ сайн хувьтны эрэл хангагч хэмээх судар оршив” гэдэг судар бол Галданцэрэн ханы зарлигаар 1744 онд дахиж орчуулж барласан юм. Уг судар Илийн Хасаг үндэстний өөртөө засах жэүгийн Монголхүрээ саянийн Шат саянийн Очирын Намжил гэнгээд хадгалагдаж буй. 10х55 см, 34 хуудас. Тус судар Монгол улсын ШУА-ийн Хэл зохиолын хүрээлэнд бас 1 хувь хадгалагдаж буй. Төгсгөлийн үгэнд

«kemēn blama dēdū yur=ban erdeni-dū yibēl yabūlxutun kütölbū=riyin sedkilge sayin xubitani erel xangyaqči kemēkū öüni šajin bariqči gūši xāni yijour ündü=sülel büyibei ubasanja ene metü nigen kereq-tei kemēn basa basa duraduqsan-du šütēd sarawa ržanjđ očir_dhara dgün_mčooq yar_gbel ečige küböün tabuni nigen čooq-tu saran aldariyin xubil=γān yurban ači tögü=süqsen xamugi ayiladuq=či manjuširi müšēkū oči=riyin yiletüyin šabi sgü_mang jor_pa blama sbdhi_lkxai kemēkū eši uxāni türbil-noγoudi orkiĵi yartu abxui kütölbüriyin sedkilge-yin tödüi todorxoi bayiyouluqsan -ni bičieči ni dge_čhül ryin_jen_bjang_pu bui šajin-du oroxuyin dēdū öödün itegeliyin kütölbür öüni šajini čooq yurban ači tögüsüqsen blama erde=ni kigēd šariyin šajini öqligüyin ejen dgā_ldan_zhereng wpang_po_tani jarliĵ šažayin toyin rab_žams_pa xutuqtu kigēd mergen blamatan xoyoriyin kürbülgeyin xoyino-ēče daxād dge_slong šes_rab_ržmcho modun xuluyana jil kürbülün түб_pa_sžab čāsun-du boulyabai tegēd bartu seiylbei»⁶.

Тус төгсгөлийн үгэнд доорх мэт мэдээнүүд багтаж буй.

1. Энэ судрыг анх Ойрадын алдарт хошууд Гүүш ханы хойч Бүүвэй увсанз хэмээх дурдсан байна.

⁶ Шашинд орохын үүд итгэлийн хөтөлбөрийн сэтгэлгэ сайн хувьтны эрэл хангагч хэмээх судар оршив. Модон бар. 10х55 см. 34 хуудас (хуудасны хоёр тал). Шинжааны Илийн Хасаг үндэстний өөртөө засах жэүгийн Монголхүрээ саянийн Шат киргиз үндэстний сумын Очир Намжилын хадгаламжид буй. 33b-34a.

2. Лхасын Гомон сүрба Содиблаким төвд хэлээр зохиосон байжээ.
3. Төвд хэлнээс орчуулсан Равжамба хутагт ба Мэргэн лам.
4. Хойно дахин Галданцэрэн ханы зарлигаар гэлэн Шаравжамц хэмээгчээр Равжамба хутагт ба Мэргэн ламын орчуулгыг лавлан байж дахин орчуулсан ба барласан.
5. Орчуулсан ба барласан цаг нь модон хулгана жил

Дуртгагч Бүүвэй увсанзын намтар түүхийн тухай баримт олдохгүй байна. “Шашин баригч Гүүш хааны язгуур үндэслэл” гэж байгаагаас үзэхэд Бүүвэй увсанз хэмээгч Хөхнуур, Төвдийг эзэлсэн хошууд Гүүш ханы хойчис болох нь тодорхой. Түүний зохиогч нь Лхасын Гомон сүрба Содиблаким болохоор төвд хүн бололтой. Зая бандидын намтар “Сарны гэрэл”-д Гомон сүрба хэд хэдэн удаа гардаг.

Тэмдэглэл нэг: “Тэнд Агва Номын хаан: Равжамба хутагтад хорсүм илгээв хэмээн мэргэчүүдэд өгүүлэн Их Гоман сүрбад өгүүлсэнд Гоман сүрба ч “Чиний зөв, Равжамба хутагт ямаар (хэрхэн) таалсан буй” хэмээв. Хойно Хутагт баруун тал өөд болсонд “Агва Номын хааны тэр үгээр таныг хорсүм илгээв гэнэ, үл байна уу? Түүнийг та тэгж юунд ам авав” хэмээсэнд үгийн дуугаар бас эндүүрснээ мэдээд аяар мухадхан үйлдэж булаалдан хэлэлцсэнд Гоман лам ч зөвийг нь мэдээд Од олон боловч сарны гэрэл илүү амуй хэмээн гайхан магтсан ажээ” (Зая бандида, 1999:33-34).

Тэмдэглэл хоёр: “Цэцэн цорж Намхайжамцад залбирах хийгээд биеийн төрөл өөд болох, ерөөл лүгээ сэлт нэгэн хэрэгтэй хэмээн их буяны нөхөр садан Гоман ловон сүрба Агваанбалжир хийгээд Гунтан гавж Лувсан эхлэн, [28г] мөн Цорж түүний шавь нарын дурдсанд шүтэж Сахорын бандид найруулсан бичээч нь Шинэ оронт Жамьян буй” (Зая бандида, 1999:174).

Тэмдэглэл гурав: “Агва Номын хаан Равжамба цорж Намхайжамцын хойт шүтээнд цагаан мөнгөөр бүтсэн Майдарын өндөр хэмжээтэй биеийг Гомон ловон сүрба Агваанбалжир хийгээд Гунтан гавж Лувсан [30г] тэргүүтэн захиран үйлдэж босгосон цагт, батад суух энэ мэт нэгэн хэрэгтэй хэмээн дурдсаны тулд Сахор бандида найруулсны бичээч нь Шинэ оронт Жамьян буй” (Зая бандида, 1999:177).

Тэмдэглэл дөрөв: “Тэнд Очирт тайж могой жилийн зул сард зууд хүрэв. Хувилгаан гарахын туст урьд Гомон лам бичиг барьсанд бичгийн хариу ийн хэмээн зарлиг болов” (Зая бандида, 1999:180).

Тэмдэглэл тав: “Өвлийн тэргүүн сарын арван долоонд Ховдод өргөөндөө буув. Тэнд Гомон лам торгуудаас ирсэн буй” (Зая бандида, 1999:240).

“Сарны гэрэл”-д Гомон сүрба гэдэг хүн таван удаа гардаг. Үүнд тэмдэглэл нэг бол 1640 оны зун Агва номын хаан ба Зая бандидын ном булаалдсан тухай тэмдэглэл болно. Зая бандидын зөв атал буруу шүүснийг Гомон сүрба сонсоод Од олон боловч сарны гэрэл үлэмж хэмээн гайхан магтсан ажээ. Зая бандида 1651-1652 оны хооронд Төвдөд очиж байсан болохоор Гомон сүрба лугаа болсон дээрх ярилцаан ч мөн онд болсон байх ёстой.

Тэмдэглэл хоёр бол 1662 онд Зая бандида таалал төгссөний дараа Гомон сүрба тэргүүлэн Зая бандидад залбирахуй, хойд төрөл өөд олохуй, ерөөл зэргийн тусад V Далай ламд дуртган магтаал бичүүлж байжээ. Тэмдэглэл гурваас үзэхэд Зая бандида таалал төгссөний дараа жил нь буюу 1663 онд мөн Гомон сүрба тэргүүлэн V Далай ламд даатган Зая бандидын шүтээн хөрөгт ерөөлийн шүлэг бичүүлж байв. Тэмдэглэл дөрвөөс үзэхэд Гомон сүрба 1665 оны орчим Зая бандидын хувилгааныг тодлох учирт V Далай ламд захиа бичиж байв. Тэмдэглэл таваас харахад Гомон сүрба 1688 онд Ижил, Зайн торгуудаас Зүүнгарт ирж Галдан хантай уулзаж байлаа.

Дээх тэмдэглэлүүдээс үзэхэд Гомон сүрба нь Зая бандида лугаа хуучин танил төдийгүй, гүн зузаан найр талтай байсан нь тодорхой. Ялангуяа Зая бандида таалал төгссөний дараа түүний хойдын буяны төлөө, жич хувилгааныг тодлох зэрэг ажлыг ихэд анхааран хамжиж байжээ. Гомон бол Төвдийн Бэрээвэн хийдийн дацан мөн. Тийнхүү Гомон сүрба нь Бэрээвэн хийдийн лам болох нь ч тодорхой буюу.

“Сарны гэрэл”-д гардаг энэ Гомон сүрба нь “Шашинд орохын үүд итгэлийн хөтөлбөрийн сэтгэлгэ сайн хувьтны эрэл хангагч хэмээх судар оршив” номыг зохиосон хүмүүн лугаа ижилхэн нэг хүмүүн мөн үү биш үү? цаашид судалж үзэх хэрэгтэй. Энэ тухай Төвд сурвалжийг ашиглавал түүний намтар түүх улам тодрох боломж их юм. Харин орчуулагчийг Рабжамба хутагт ба Мэргэн лам гэж байхаас үзэхэд энэ судрыг Зая бандида ба түүний шавь Мэргэн лам хамжин орчуулсан нь тодорхой.

“Сарны гэрэл”-д Мэргэн лам гэдэг хүмүүний нэр гардаггүй боловч Мэргэн хэлмэрч гэдэг хүн гарч буй. Мөн түүний үйл ажиллагаа голдуу Зая бандидын таалал төгссөний дараа сая гардаг.

Тэмдэглэл нэг: “Могой жил (1665)-д Очирт тайж зуны тэргүүн сард Хөх уснаас баруун тал явав. Тэр үед Эрх цорж шавь нарыг эзэлсэн цаг мөн. Тэнд Мэргэн хэлмэрчийг илгээж хувилгаан гарсан эс гарсныг дээр [Далай ламд] айлтгаж мэдэж ир хэмээн илгээв” (Зая бандида, 1999:179-180).

Тэмдэглэл хоёр: “Могой жилд Хэлмэрч [Зууд] хүрээд бас бичиг барив. Хариуд [нь]: “Галзуу мөрнийг гаталж Хар хотын Чансанд эргин (хавьд) бэдэр” хэмээн зарлиг болов. Урьд Ламын гэгээн Бодала дээр тэнийхээр өөд болсон цагт. Чодвонд Хархот зүг хомхой зүглэж, Агва цэцэн цорж тэнд хувилсан буй хэмээн зарлиг болсон [31г] ажээ. Тэндээс Хэлмэрч дэмий бэдрэхээр одсонд, табур тубур мод тарьсан нэгэн хүрээд цагаан морь хүрээд байх нэгийг үзээд энд хоног үйлдэе хэмээн бууж орсонд, түүний урьд бяцхан хүүхэн ч: “Гийч монгол айшина (айсуй)” хэмээж зарлиг болсон ажээ. Хэлмэрч гэрт орон (орж) дэвсгэрт суусанд хүү ч эхийн өвөр дээр суун харан харан ахуйд, Хэлмэрчийг: “Ирж үрэл залги” хэмээсэнд хүү ч бишүүрхэлгүй Хэлмэрчийн өвөр дээр ирж үрэл залгиж өвөр дээр суув. Хэлмэрч шивнэж: “Хутагтын хувилгаан мөн буюу?” хэмээсэнд “Мөн” хэмээв. Тэнд хонож эцэг эх лүгээ хэлэлцэн ахуйд, “Та монгол юунд явав?” хэмээсэнд, “Саннү хийдэд мөргөхөөр ирлээ, энд хоног үйлдэх мөн” хэмээв. Тэнд хэлмэрч эх лүгээ хүүнэлдэн: “Энэ хүү түрүүн умайд ороход бэлгэ тэмдэг хийгээд хэл гарахуйд юу өгүүлнэ?” хэмээсэнд эх нь: “Ийн түрүүн болох цагт нэгэн их лам өөд болж номт дээл соёрхов. Хэл орох цагт адабиш хэмээн өгүүллээ. Тэр үг манай Тангадт үгүй үг мөн” хэмээв. Тэнд [31v] хоноод тэдэнд юм хэлэлгүй харьж ирэн Дээр айлдсанд, “Би урьд юу хэллээ?” хэмээн зарлиг болсонд “Табур тубур мод тарьсан хүрээд цагаан морь уясан тийм газарт хувилсан буй хэмээн зарлиг боллоо” хэмээн айлтгасанд, “Тэгвэл тэр мөн буй за” хэмээн зарлиг болов” (Зая бандида, 1999:193).

Тэмдэглэл гурав: “Тэр тахиа жил (1669)-ийн зунд Эрх цорж тэргүүлэн бүдүүн шавь нар бүгдээр Хувилгаанд золгохоор зуны тэргүүн сарын сайн өдөр Лэбшээс баруун тал явав. Олон нуурыг дайран нуур хөвөөлж Мянгэн таягаар гаран Эрээн хавиргаар бэлдэн явсанд халуун батгана их болон тэмээний таваг хавдан малд гамшиг болсонд, тэнд Дөрвөлжинд өчүүхэн түдээд явав. Тэндээс Тал начинд хүрээд говийг хоёр анги (тусдаа) туулав. Эрх цорж олон шавь нар Хоёр сайханаар туулав. Хэлмэрч нэг хэсэг хүн Үйвэн хараатаар туулав. Хэлмэрч Хар даваагаар давж Хөх нуурт хүрч, [32v] Давсны говьд Булодой дээр өвөлжив. Эрх цорж Ороо ичээд санд хүрээд баруун тал явав. Тэндээс бас харин ирээд. Бас баруун тал намар одов. Тэнд Мэргэн хэлмэрч нохой жил (1670)-ийн зуны тэргүүн сарын сайн өдөр Давсны говиос баруун

тал Хулсан сүвээр явж зуны сүүл сард Дамд хүрэв. Тэнд Мэргэн хэлмэрч хувилгааны дэргэд өнө байхын тул Дамд байв” (Зая бандида, 1999:183-184).

Тэмдэглэл дөрөв: “Тэр цагт Хэлмэрч ч Шаврунгийн дэргэд байсан буй. Тэнд Эрх цорж Зууд өвөлжин цагаан сарын ерөөл сонсоод гахай жил (1671) ургуулж зуны дунд сар Сэртэнд сууринчдаа хүрч ирэв” (Зая бандида, 1999:193).

Дээрх тэмдэглэлээс үзэхэд Зая бандидын доор Мэргэн хэлмэрч гэдэг үнэнч шавь байсан ба ялангуяа Ойрад ба Төвдийн хооронд хэлмэрчийн ажлыг хийж байсан нь тодорхой. Энэхүү Мэргэн хэлмэрч ба Мэргэн лам нь нэг хүн үү биш үү гэдгийг бас цаашид тодлох чухалтай.

“Сарны гэрэл”-д Мэргэн ламын үйл ажиллагаа голдуу Зая бандидын таалал төгссөний дараа нялх Шаврун лугаа холбогдон гарч буй.

Тэмдэглэл нэгээс үзэхэд урьд нь Их Хүрээний Эрх цорж эрх мэдсэний дараа 1665 Мэргэн ламыг Төвд зүг явуулж хувилгаан илэрсэн эсэхийг Далай ламаас асуулгасан байна. Мөн жил Төвд хүрээд Далай ламд бичиг барьсанд Хархотод илэрсэн тухай зарлиг болж, мөн Мэргэн ламыг томилон тодлуулсан ба Мэргэн лам ч Зая бандидын хувилгааныг эрж олоод түүнийг Далай ламд айлтгасан байна. Тэгээд Мэргэн лам удалгүй буцсан юм. Юу гэвэл 1669 онд Эрх цорж тэргүүлэн бүгд шавь нар хувилгаанд золгохоор Төвд зүг мордогсдийн дотор Мэргэн лам байсан ба Хар даваагаар даван 1670 онд Дамд хүрч хувилгааны дэргэд байв. Мөн дараах тэмдэглэлийг үндэслэвэл тэрбээр 1671 онд болтол хувилгааны дэргэд байсан гэдэг нь тодорхой.

Мэргэн ламын намтар түүх зөвхөн 1665 оноос 1671 оны 6 жилд холбогдон гарч байна.

“Шашинд орохын үүд итгэлийн хөтөлбөрийн сэтгэлгэ сайн хувьтны эрэл хангагч хэмээх судар оршив”-ын зохиогдсон цаг ба орчуулсан цагийг цөм дурдсангүй. Гүүш хан 1636 онд Ойрадаас мордож 1637 онд Халхын Цогт тайжийг мөхөөн Хөхнуурыг эзлэн, дахин Төвд зүг цэрэглэн 1642 онд Цастын Төвдийн оронд Хошууд хаант төрийг байгуулсан билээ. Зая бандида 1662 онд таалал төгссөн болохоор уг судар 1642-1662 оны хорин жилд зохиогдсон буюу орчуулагдсан бололтой.

Галданцэрэн хан сууринд байсан 1727-1745 оны үед модон хулгана жил ганц удаа тохиолдох ба тэр нь 1744 он болохоор тус судрыг мөн онд орчуулаад барласан гэдэг нь ч тодорхой (Лувсанбалдан, 1975:120).

Орчуулан барласан Шаравжамцийн намтар түүх бас тодорхой биш. Юу ч гэсэн Галданцэрэн ханы үед Шаравжамц гэдэг нэртэй орчуулагч байсан нь тус судрын төгсгөлөөс тодорхой мэдэгдэж буй. Түүнээс үзэхэд энэ судрыг Галданцэрэн хан таалал төгсөхийнхөө өмнөхөн жил зарлиг буулгаж орчуулуулсан ба барлуулсан байжээ. Энэ судар дээрх “Алтангэрэл”, “Таслагч очир”, “Найман мянгат” мэт олон эхүүд лүгээ шүүн тулгаж, эндүүрэл бурууг зассан биш, харин Зая бандида ба Мэргэн ламын орчуулгыг мөрдөж дахин орчуулсан юм. Тийнхүү шүүж ариутган хэвлүүлсэн бурханы зохионгуй лугаа ижилсэх тал байх мөртөө бага ялгаатай зүйл ч буй тул түүнийг дахин орчуулсанд багтаан үзэх нь зохистой.

Дээрх судар номууд дотор Галданцэрэн ханы зарлигаар орчуулсан анагаах ухааны зохионгуй буй. Мөн түүний зарлигаар дахин орчуулан барласан судар ч буй. Эдгээр нь Галданцэрэн ханы үе буюу 18-р зууны өмнө хагаст холбогдох тод үсгийн бурханы шашны судар номын үйлсийн агуулгыг улам баялаг болгосон төдийгүй, тухайн үеийн судар номын үйлсийг улам нэг алхам ойлгохын түлхүүр болж буй.

Дээр нэгэнт ярьсан мэт 1745 онд Галданцэрэн хан таалал төгссөн болохоор “Шашинд орохын үүд итгэлийн хөтөлбөрийн сэтгэлгэ сайн хувьтны эрэл хангагч хэмээх судар оршив” бол түүний нас барахын түрүү жилд явагдсан ба мөн ч 18-р зууны өмнө хагас үед Зүүнгарт тодчилогдон барлагдсан хамгийн сүүлийн судар болно. Галданцэрэн хан буюу Зүүнгарын тод үсгийн бурхан шашны судар номын үйлс үүгээр сүүл хурааж төгссөн ажээ.

4. Содномдулам хатны зарлигаар шүүн ариутган хэвлүүлсэн “Хутагт Дарь эхийн хорин нэгэн магтаал хэмээх оршив”

Тус судар Илийн Хасаг үндэстний өөртөө засаг жэугийн Тэхэс сянийн Досаны хадгаламжид буй⁷. Модон бар. Гарчиг байхгүй, эхэн төгсгөл дутуу, 19 хуудас, 13а хүртэл бурхны зурагтай. Тус судрын тухай миний бие 2005 онд нийтлүүлсэн өгүүлэлдээ “Энэ бол Зая бандидын орчуулга. Гэхдээ гаргасан цаг нь мэдэгдэхгүй” (Мянгад Эрдэмт, 2005) гэсэн билээ. Харин азаар 2007 оны өвлийн амралтад дахинтаа Илийн Хасаг үндэстний өөртөө засах жээд хээрийн шинжилгээ хийхдээ Монголхүрээний сянийн Харганат (цэргийн агтны талбай)-ийн Бадрахын Бадамжав⁸-ын хадгаламжид байсан уг судрын бүрэн эхийг олж авсан билээ. Бадамжавын дэвтрийн хэмжээ 9.5х27.5 см, хар бэх, 20 хуудас, хуудас болгон 15 мөртэй, 1-2 хуудас хүртэл ба хамгийн сүүлчийн хуудас болгонд хоёр бурхны зурагтай, 3-14 хуудас хүртэл хуудас болгонд ганц ганц Дарь эхийн зурагтай, 15-р хуудаснаас хойш зураг байхгүй. Уг судар бас Монгол улсын ШУА-ийн Хэл зохиолын хүрээлэнгийн номын санд 1 хувь хадгалагдаж буй. Тус судар хоёр төгсгөл үгтэй.

Нэгдүгээр төгсгөлийн үг:

«āra dare ekeyin ene suduri arban čagān buyani aqlaq-eče xurāqsan-yēr ayimaq yeke ulušyin ejen bolun töröqsöün ariun süjüqtü tayiši duruduqsan-du xamuq ulus dare eke-dü biširen šütüqtü ara jüqyin dörbön šumnuši darād xaril ügei burxani dörbön beye olxuyin tula yayixamsiq töböbyin kelen-eče monggolčiloboi tayin čecen rab_jamba za_ya»⁹.

Дээрх төгсгөл үгээс үзэхэд доорх мэт зүйлсийг мэдэж болно.

1. Энэ судрыг орчуулахыг дурьдсан хүн бол Тайш,
2. Орчуулсан хүн бол тойн цэцэн Равжамба Зая.

Судар орчуулахыг дуртгагч Тайш гэдэг хүн бас тайш Ахай зэрэг нэрээр гардаг. Энэ хүн бас 1642 онд Ачит цорж, Очирт тайж лугаа “Банчин хутагтын тууж”-ийг дуртган орчуулуулж байжээ. Тайш буюу тайш Ахай нь хошуу ноён Очирт тайжийн хатан байсан бөгөөд энэ хатан 1644 онд Биж гэдэг газар нас барсан тухай Зая бандидын намтар “Сарны гэрэл”-д гардаг. Тиймээс энэ орчуулга нь 1644 оноос өмнө явагдсан гэдэг нь тодорхой байна. Орчуулсан хүн Тойн цэцэн Равжамба Зая бол бидний сайн мэддэг Зая бандида Намхайжамц мөн.

Хоёрдугаар төгсгөл үг:

«šaryin šajini öqligüyin ejen-ni xatun bsod_nam ggrol_ma sajin töröyin üyiledü šidar ekelen kēčin-dü šine ariun ene metü dāre ekeyin suduri šajin töröyin kereqtü keb-tü siyilgeqsen jarliqyār urida rab_jam za_ya xutugtuyin gegēn ariun körbölüdsen-eče ulam jabsar-tu bičēči terigüüteni erkēr endöürüqsen бүгүдеиги уралан dold dge_slong čö_bzangpo tayilburi kigēd ulamši ariun eke bičigüüdtü tulγan šüüji udal ügei šine ariudxād keb-tü siyilgen daruulbai»¹⁰.

Дээрх төгсгөл үгээс доорх мэт зүйлсийг мэдэж болно.

1. Уг судрыг дурдган шүлэглэгч нь Содномдулам,
2. Зая бандидын орчуулсан эхийг ариутган шүүж Дүлэв гэлэн, Чойсамбуу хэвд даруулсан.

Уг судрыг дурдган шүлэглэгчийн намтар түүхийн тухай бидний гарт тодорхой мэдээ олдоогүй. Равжамба хутагтын гэгээн гэдэг нь Зая бандида Намхайжамц болно. Тиймээс бид

⁷ Досан – Эрэгтэй, 39 настай, багш. 2004 оны 6 сарын 12-ы өдөр би Шинжааны Илийн Тэхэс сянийн Дөрөвдүгээр дунд сургуулийн захирал Досан багшийн гэрт сурвалжлага хийхэд уг судрыг үзүүлсэн билээ.

⁸ Бадрахийн Бадамжав - 1969 онд төрсөн. Шинжааны Илийн Хасаг үндэстний өөртөө засах жэугийн Монголхүрээ сянийн Харганатын хүн. Зургаан сумны бага суман. Өвөг Цагааны үеэс эхэлж судар хадгалжээ. Өвөг Цагаан нь нас барсанд аав Бадрах нь уг судруудыг олон жил хадгалж байгаад Бадамжавт уламжилсан байна.

⁹ *Хутагт дарь эхийн хорин нэгэн магтаал хэмээх оршив*. Бадрахын Бадамжавын хадгаламжид буй. 18а-19а.

¹⁰ *Хутагт дарь эхийн хорин нэгэн магтаал хэмээх оршив*. Бадрахын Бадамжавын хадгаламжид буй. 19а-20а.

барласан тодорхой цагийг тогтоож чадахгүй ч Зая бандидын угийн орчуулгыг сүүлд нь шүүж ариутгаад барласан гэдгийг мэдэж болно. Нөгөө нэг ариутган шүүж хэвд даруулсан Дүлэв гэлэн, Чойсамбуугийн тухай ч бид сайн мэдэхгүй байсаар. Гэхдээ энэ судар мөнхүү 18-р зууны модон бараар байж болох юм. Яагаад гэвэл нэгд, 18-р зууны тод барын үсгийн тиг нь тийм том биш нарийхан, будаг нь гүн, хар зэрэг онцлогтой байдаг. Тус сударт тиймэрхүү онцлог тодорхой харагдаж байна. Хоёрт, дээр ярьсан “Рашааны зүрхэн найман гишүүт нууц увдис эрдмийн үндэсний халаалт хадгалахуй халууны энэлэг ариулахуй хадбур цаг бусын үхлийн цалам таслах илд”-ийн орчуулагч бол мөн Чойсамбуу хэмээх нэртэй. Тийнхүү энэхүү судрыг хэвд даруулсан лугаа нэг л хүн болох нь тодорхой. Тэр нь уг судар мөн цаг үед барлагдсан гэдгийн хамгийн чухал баримт болно. Гуравт, энэ судрын төгсгөл үгэнд гардаг Шарын шашны өглөгийн эзэн нь урьд Равжамба хутагтын гэгээн ариун хөрвүүлснээс улам завсарт бичээч тэргүүтний эрхээр эндүүрсэн бүгдийг гэдэг нь Галданцэрэн ханы үед шүүж ариутган хэвлүүлсэн судар номын төгсгөлд зөндөө тохиолддог. Тийм болохоор дээрх судрыг бид мөн Галданцэрэн ханы үеийн судар номын үйлст оруулж буй.

Тод сурвалж судлалын суурьлагч эрдэмтний нэг Монгол улсын Х.Лувсанбалданы мэдээлснээр “Рашааны зүрхэн найман үет нууц увидасын үндсээс дөтгөөр хэсэг хойд үндсэн хэмээх” модон бар буй ба барласан он цаг нь тодорхойгүй. Гэвч цаасны байдлаас үзэхэд мөн Галданцэрэн ханы үед барласан байж болох юм гэж мэдээлж өнгөрөв (Лувсанбалдан, 1975:121).

Галданцэрэн хан 1745 онд нас барсан болохоор “Рашааны зүрхэн найман үет нууц увидасын үндсээс дөтгөөр хэсэг хойд үндсэн хэмээх” судар үнэхээр түүний цаг үед барлагдсан бол 1741-1745 оны хооронд байх ёстой. Мөн тэр нь зүгээр барласан уу? эсвэл шүүн ариутган барласан уу? Хойшид энэ тухай үргэлжлүүлэн баримт эрэх хэрэгтэй.

Товч дүгнэлт

Дээр бид 18-р зууны өмнө хагас буюу Зүүнгарын Галданцэрэн ханы бурхан шашны судар номын үйлсийн тухай тойм судалгаа хийлээ. Тухайн үеийн тод сурвалжийн олонх нь гээгдэн сүйдсэн бололтой. Гэвч цөөн олдсон тэдгээр сурвалжид суурилан 18-р зууны эхэн үеийн Галданцэрэн хан буюу Зүүнгарын шашин номын үйлсийн тухай доорхи мэт хураангуйлал хийж болно.

1. Галданцэрэн ханы анх дуртган орчуулуулсан нь анагаах ухааны судар болох “Увидас эрдмийн үндэсний халууны энэлэг арилгахуй хадбур цаг бусын үхлийн цалам таслах илд оршив” болно. Тус номыг төмөр гахай жил буюу 1731 онд Галданцэрэн ханы зарлигаар эмч Лувсаннамжил болон олон сайн эмч нэртэй агва гэцэл Чойсамбуу орчуулжээ. Энэ бол бидний гарт одоогоор олдсон Галданцэрэн хан төдийгүй бүхий л 18-р зууны өмнө хагаст холбогдох Зүүнгарын тод үсгийн шашин номын үйлс лугаа холбогдох хамгийн эртний мэдээ болно. Тус судрыг Галданцэрэн ханы сууринд сууснаас дөрвөн жилийн дараа орчуулсан юм.

Эдүгээ бидний гарт Галданцэрэн ханы эцэг асан Цэвээнравданы засаг барьж байсан үе (1698-1727)-ийн тод үсгийн бурхан шашны сурвалж нэг ч олдохгүй байсаар. Шинээр олдсон “Увидас эрдмийн үндэсний халууны энэлэг арилгахуй хадбур цаг бусын үхлийн цалам таслах илд оршив” нь 18-р зууны өмнө хагаст Зүүнгарын тод үсгийн шашин номын үйлсийн эхлэлтийн цэгийг тогтоохын зангилаа болж буй. Манай үзэлтээр 18-р зууны өмнө хагаст Зүүнгарын шашин номын үйлс 1731 он болоход нэгэнт эхэлсэн байна.

2. Галданцэрэн хан 1741 онд “Алтангэрэл”, “Таслагч очир”-ийг, 1742 онд “Найман мянгат”-ийг тус тус шүүж ариутган барлуулсан байжээ. Ойрадын түүхэн дээр Галданцэрэн

ханаас өмнө буюу хойно бурхан шашны зохионгуйг шүүн ариутгаж хэвлүүлэх ажил ерөөс байж өнгөрсөнгүй юм. Тийнхүү Галданцэрэн хан Ойрадын түүхэнд урьд гараагүй аугаа их үйлсийг бүтээсэн байдаг.

1741-1745 оны хооронд “Рашааны зүрхэн найман үет нууц увидасын үндсээс дөтгөөр хэсэг хойд үндсэн хэмээх”, 1744 онд “Шашинд орохын үүд итгэлийн хөтөлбөрийн сэтгэлгэ сайн хувьтны эрэл хангагч хэмээх судар оршив” зэргийн зарлиг буулган модон бараар хэвлүүлсэн байжээ. Гэвч “Рашааны зүрхэн найман үет нууц увидасын үндсээс дөтгөөр хэсэг хойд үндсэн хэмээх” судрыг чухам хэзээ барласан гэдгийг цаашид баримт хайх хэрэгтэй. Сонирхолтой нь Галданцэрэн хааны үед шүүж ариутгасан судар олонхи тоог эзэлж буй. Шүүж ариутган хэвлүүлэх бол 18-р зууны өмнө хагаст холбогдох Зүүнгарын тод үсгийн бурхан шашны судар номын үйлсийн гол тэнхлэг мөн.

3. Эдүгээ бидний гарт үлдсэн Галданцэрэн ханы бурхан шашны судар номын үйлсийн эхлэлтийн цэг нь 1731 он, төгсгөлийг түүний нас барсан 1745 он гэж үзэхэд ямар ч асуудалгүй. Тийнхүү түүний шашин номын үйлс 1731-1745 оны 14 жилийг хамарч буй. 1731 оноос өмнө буюу Галданцэрэн хан суусны дараа судар ном орчуулуулж байсан уу, үгүй юу? Одоогоор баримт олдоогүй. Гэтэл түүний шашин номын үйлсийг завал 1731-1745 оны 14 жилд явагдсан гэж тасархай хэлж ч болохгүй юм.

Энд бас чухалчлан дурдах ёстой зүйл бол тухайн үед Галданцэрэн ханы хан ордонд маш олон нэрт хэлмэрчид идэвхтэй ажиллаж байжээ. Тэд тод үсгийн бурхан шашны судар номын үйлст үнэнчээр зүтгэж, өөрийн хувь нэмэрээ оруулж байсан юм. Орчуулагч эмч Лувсаннамжил болон олон сайн эмч нэртэй агва гэгцэл Чойсамбуу, шүүж ариутган бард сийлэгч ламрим гэлэн Агваанжамъян, сангасва гэлэн Самбуужамц, тойзамлин гэлэн Раашжалцан, гэлэн Лүнрэвжамц дахин орчуулаад хэвд сийлж байсан Шаравжамц нар бол Галданцэрэн ханы үе буюу 18-р зууны өмнө хагаст амьдарч байсан Зүүнгарын алдарт орчуулагчид мөн. Тэдний намтар түүхийн тухай бидний мэддэг нь бага, мэддэггүй нь их байсаар. Тухайн үеийн тод үсгийн судар номын үйлсийг тэргүүлэн хийж, уйгагүй хөдөлмөрөөрөө Ойрадын соёлыг түгээж явсан тэдний гавьяа зүтгэлийг мөн зүй ёсоор тэмдэглэвээс зохистой.

4. “Алтангэрэл” бол Хамаг судрын хаан гэгддэг. Одоо ч Илийн голын урсгал дагуу оронд “ном нээх” хэмээх сонирхолтой зан үйл буй. Тод үсгийн бурхны судрыг лам хувраг биш, харин хар хүн уншдаг. Олон судрыг зэргээр нээхэд заавал “Алтангэрэл”-ыг эхэнд нь уншдаг. Мөн олон номыг зэрэглэн тавихад “Алтангэрэл”-ыг дээд талд нь тавьдаг. Үүнээс түүний байр суурь ба хэр зэргийн хүндэтгэл үзүүлдгийг олж харах аж. Түүнд төр гүрнийг бататгах, ард иргэдийг амгалан болгох шид хүч байдаг гэдэг болохоор бурхан шашныг тэтгэсэн эл үеийн хаад ноёд цөм орчуулуулах, барлах зэрэг дэлгэрүүлэх ажлыг хийсэн байдаг. Тийнхүү Галданцэрэн ханы үед “Алтангэрэл”-ыг барлуулсан нь ойлгомжтой хэрэг юм. Тод үсгийн сурвалж дотор хамаг олон дэлгэрсэн чухал судрын нэг нь энэ “Алтангэрэл” болно.

“Таслагч очир” нь нөгчсөнд уншиж сүнс мөрийг нь гэтэлгэгч үйлдэлтэй төдийгүй, тахисан хүнийг өвчин гэмээс хагацуулах чадавхи буй гэдэг. Тийнхүү тод үсгийн сурвалж дотор хамгийн их дэлгэрсэн бөгөөд хамгийн олон барлагдсан судар болох юм.

Илийн нутагт “Найман мянгат” бол их найр болоход нутгаа даалгаж бүх ардаараа нээлгэх судар мөн. Хэдэн өдрийн үргэлжилсэн найр болоход олон хар багш нар зэрэглэн сууж, нийт олны амар амгалангийн төлөө нэгддэг. “Найман мянгат”-ын гар бичмэл ч болон, модон бар ч болсон эдүгээ олдсон тод үсгийн сурвалжийн дотор хуудасны тоо хэмжээгээр хамгийн том судар болно. Мөн ч ойрадчуудын бүтээсэн хамгийн том шүүж ариутган хэвлүүлсэн ном болох юм.

Тийнхүү Галданцэрэн ханы үед дээрх судар номыг зөвхөн дураар сонгон шүүж ариутган барласан биш гэдэг нь мэдэгдэж буй. Жинхэнэ шашин номын дэлгэрэн хөгжихөд ашигтай зүйлсийг зорилготойгоор сонголт хийсэн гэдэг нь харахаас ил. Харин анагаах ухааны судрыг анхлан орчуулуулж байснаас үзэхэд Галданцэрэн хан нууц хуйвалдлага дор хоронд хорлогдсон эцгийнхээ хойноос эмгэнэн гашуудаж байснаас болсон ч юу магадгүй.

5. 1741 он буюу Галданцэрэн ханы үед барласан тод үсгийн модон бар бол одоо мэдэгдээд байгаа Ойрадад нутагт ном судар барлаж байсан тухай хамгийн эртний мэдээ болно. Галданцэрэн ханаас өмнө Ойрадад ном хэвлэж байсан тухай баттай мэдээ одоогоор олдоогүй байна. Тэр нь мөн ч ойрадуудын анхны шүүж ариутган хэвлүүлсэн ном болно. Шүүж ариутгаж, мөн барлах ажлыг гүйцэтгэж байснаас үзэхэд Зүүнгарын тод үсгийн бурхан шашны судар номын үйлс нэлээд боловсрон төгөлдөржсөн шинэ шатанд орсны бэлгэ тэмдэг мөн.

Галданцэрэн хан маш том номын сантай байсан ба түүнийгээ Зүүнгарын их нүүдлийг даган тэмээнд ачиж явдаг байсан талаар “Халимагийн хан Галданцэрэн үргэлж хоёр зуун тэмээгээр өөрийн номоо ачиж явдаг. Ганц Ганжуур зуун боть, нэвтэрхий толь маягийн Данжуур судар багадаа 225 ботиос дутуугүй. Боть бүрийн хүнд нь 4-5 фунт байна” (约·巴德利, 1981:103-104) гэж тэмдэглэжээ. Тэрбээр өөртөө ном судар хадгалж байсан төдийгүй бас ном барлуулах ажлыг ч хийж байсан нь сонирхолтой. Тиймээс Галданцэрэн ханын үед Ойрадын бурхан шашны судар номын үйлс дахин өрнөн хөгжсөн байна. Ялангуяа модон бараар ном хэвлэх болсон нь Ойрадын бурхан шашны судар номын үйлсийн бас нэг том амжилт. Даруй Галданцэрэн хан Ойрадын ба тод үсгийн ном барлах, шүүж ариутган хэвлүүлэх ажлыг эхлүүлсэн гавьяат зүтгэлтэн мөн.

6. Хэлэлгүй Зая бандида бол тод үсгийн зохиогч мөртөө тод сурвалжийн буй болж бүрэлдэхийн суурилагч мөн. Эдүгээ уламжлагдан ирсэн тод сурвалжийн олонхи нь түүний орчуулга болно. Гэтэл түүний цаг үед тод үсгийн бурхан шашны ном судар анх буй болж бүрэлдсэн төдий. Анх буй болж бүрэлдсэн шатанд байсан болохоор түүнийг улам нэг алхам шүүн ариутгахийн чухал ч алга.

Галданцэрэн ханы үед тод үсгийн бурхан шашны судар номыг шүүн ариутган барлах болсон нь тод үсгийн бурхан шашны сонгодог бүтээлийн орчуулга улмаар биеэ дааж системжсэний шинж тэмдэг мөн. Галданцэрэн ханы цаг үед бурхан шашны судар ном нь зөвхөн гараар хуулахад түшиглэх биш, барлах, цаашид шүүж ариутгах өндөр түвшинд хүрсэн байжээ. Зая бандида бол тод үсгийн бурхны ном хамгийн олон орчуулсан хүн. Нэг үгээр хэлбэл Зая бандидын үеийн бурхан шашны судар номын орчуулга агуулгаар хамгийн баялаг юм. Гэтэл хэлбэрийн хувьд нэг цаг үед буюу цаашилбал бүхий л Ойрадын соёлын түүхэн дээр Галданцэрэн ханы үе мэт орчуулж, шүүж ариутган барлах, дахин орчуулан барлах зэрэг олон хэлбэрээр явагдсан тод үсгийн бурхан шашны судар номын үйлс одоо байхгүй юм.

Бурханы номыг монгол мэргэд эртнээс шүүж ариутгаж байсан тухай баримтууд олдож буй. 1717-1720 оны хооронд монголчууд 108 боть Ганжуур номыг шүүж ариутган Бээжин хотноо хэвлүүлэв. Түүнийг шунхан барын Ганжуур гэдэг. Тэр нь монголчуудын бүтээсэн аврага соёлын нэг мөн. Мөн ч монголчуудын шүүж ариутган хэвлүүлсэн бурханы зохионгуйн оргил бүтээл болно.

Монгол бурхны судар ном төдийгүй Төвд Ганжуур зэргийг санскрит эхтэй нь тулган шүүж байсан монгол мэргэд ч байсан. Шүүж ариутгах нь бурхны ном үе дамжин уламжлагдан явахад гарсан эндүүрэл бурууг алдаа мадаг бага ариун эх, эсвэл уул орчуулгын эх ба холбогдол бүхий бусад эхүүдтэй тулган, засан зүгширүүлэх чухал ажил юм. Галданцэрэн ханы үеийн тод үсгийн бурхан шашны судар номын шүүж ариутгах үйлс шунхан барын Ганжуур мэт сүр

далайцтай явагдсан ч биш. Гэтэл тэр нь тод үсэг ба ойрадуудын бурхан шашны судар номын үйлсийн хөгжилтөд чухал агуулгыг нэмэрлэсэн зүйл болох юм.

Эдгээр ажил Зая бандидын таалал төгссөнөөс бараг наян жилийн дараа сая биелэгдсэн юм. Түүнээс тод үсгийн бурхан шашны орчуулга биеэ даасан шинэ шатанд орсныг харуулж байгаа бөгөөд Зая бандидаас хойшхи бас нэг хөгжлийн оргилыг авчирсан байна. Тийнхүү Галданцэрэн хан тод үсэг ба Ойрадын түүхэн дээр орлуулж үл болох чухал ажлыг гүйцэтгэсэн ажээ.

7. Галданцэрэн ханы үед дуртган хэвлүүлсэн буюу шүүн ариутгаж хэвлүүлсэн ном судар нь зөвхөн бурхан шашны орчуулгын ажил төдий биш. 18 дугаар зууны түрүү хагаст тод үсэг ямаршуухан янзтай хэрэглэгдэж байсан гэдгийн чухал баримтыг хангадаг. Тийнхүү тод үсгийн хөгжилтийн чухал шат үе нь ч нэг мөн. Тод үсгийн хөгжилтийн түүх, улиран хувьссан түүхэн жимийг судлахад дутагдаж үл болох ховор нандин материалууд болох юм. Тэдгээрийг яахан шүүж ариутгасныг харьцуулан үзэхийн зэрэг үг хэл, үсэг бичгийн талаас улам лавшруулан судлах үүрэг бидний өмнө тавигдаж буй.

8. Галданцэрэн хан бол тухайн үеийн Төв Азийн улс төрч хүн мөртөө аврага их соёлын зүтгэлтэн мөн. Тэр бүхнийг түүний цаг үед бүтээсэн соёлын өв бардам гэрчилж байна. Мөн түүний гавъяа зүтгэлийг тухайн цаг үетэй нь холбож зөв үнэлэх цаг үе ч ирсэн юм. Түүний цаг үед хэвлэгдсэн тэдгээр судар ном нь үсгийн тигээс эхлэн барын хэмжээ зэрэг бүх талаар тод үсгийн модон барын эхлэлт мөртөө оргил болох бүтээл мөн. Түүнээс хойно хэвлэгдсэн тод модон бар нь судрын хэмжээ хуудас ба найрлага зэрэг аль ч талаар Галданцэрэн ханы цаг үе лугаа адилтгахийн аргагүй байдаг. Тийнхүү Галданцэрэн ханы амьд байсан цаг үе бол яах аргагүй тод барын алтан үе мөн. Харин түүний цаг үе нь судар номын үйлс өдийхнөөр зогсох ёсгүй. Тэр тухай баримт материалуудыг цаашид бүртгэн хайж, мөн цаг үеийн бурхан шашны судар номын үйлсийг улам тодруулах нь эдүгээ цагийн бидний түлхэж үл болох дархан үүрэг буюу.

9. “Хутагт дарь эхийн хорин нэгэн магтаал хэмээх оршив” бол эдүгээ болтол бидний гарт олдсон Ойрадын түүхэн дээрх цорын ганц хатан хүний дуртган ариутган шүүж барлуулсан судар болно. Гэхдээ түүний дуртгагч, шүүж ариутгагч, шүүж ариутгасан цаг зэргийн тухай цаашид баримт эрэх хэрэгтэй.

Галданцэрэн хан таалал төгсөөд удалгүй Зүүнгар дахинд дотоодын хан эрх булаалдах самуун цаг үед орсон ба 1755 онд Гэдэн уулнаа Чин улс мөхөөв. Түүнээс Галданцэрэн ханы үед эхлүүлсэн судар номын үйлс тасалдсан юм. Гэтэл 17-р зууны сүүлчээс 18-р зууны сүүлч хүртэлх зуун жил, цаашид 1648 онд тод үсэг зохиогдсоноос нааши гурван зуун жар гаруй жилийн турш Ойрад соёлын “алмаз эрдэнэ” мэт Галданцэрэн ханы бүтээсэн судар номын үйлс гялалзан харагдсаар буй.

1. “Хүчдэх дусал”-ын сөрөгтэй танилцуулга

1.1. “Хүчдэх дусал”-ын хэлтэвчлэл ба түүнийг хэмжэн

“Хүчдэх дусал” нь Өвөр Монголын багшийн Их Сургуулийн номын сангийн монгол хэргийн материалын тусгай хадгалагчид Б.А. Халдунмагийн дутар нь 01132, түүнийг хэмжээ нь 3,7х32,8 см, цаасны хэмжээгээр загвартай тусгай дотур нь тэр багээр бичигдэв. Судрын нэрт нь тод агуулгыг бичсэн үсгийн тэг нь алмазгүй. Навийн хэмсэм тогт галд барийхан үсэг

Номзүй

Алтангэрэл. Бэх шунх алагласан бичмэл. 13x48 см. 78 хуудас (хуудасны 2 тал). Шинжааны Илийн Хасаг үндэстний өөртөө засах жэугийн Монголхүрээ сянийн Шат киргиз үндэстний сумын адууч Түнэр (1955-)-ийн хадгаламжид буй.

Зая бандида. Ш.Норов тулган харьцуулж тайлбарлав. Өвөр Монголын Ардын хэвлэлийн хороо. 1999.

Найман мянгат. Модон бар. 10.9x42.7 см. 382 хуудас (хуудасны хоёр тал). Шинжааны Илийн Хасаг үндэстний өөртөө засах жэугийн Монголхүрээ сянийн хугай Бүрэнтөгсийн хадгаламжид буй.

Найман мянгат. Хулсан үзэг. Бэх шунх алагласан. 383 хуудас (хуудасны хоёр тал). Шинжааны Илийн Хасаг үндэстний өөртөө засах жэугийн Монголхүрээ сянийн Төвжаргал Төрмөнхийн хадгаламжид буй.

Таслагч очир. Хулсан үзэг. Бэх шунх алагласан. 8.5x48 см. 23а хуудас (хуудасны хоёр тал). Шинжааны Илийн Хасаг үндэстний өөртөө засах жэугийн Монголхүрээ сянийн Цагаан хонины талбайн гэгцэл Баянбатын хадгаламжид буй.

Увидас эрдмийн үндэсний халууны энэлэг арилгахуй хадбур цаг бусын үхлийн цалам таслах илд ориш. Бэх шунх алагласан хулсан үзгийн бичмэл. 11x50 см. 166b. Ринчен Нипагийн хадгаламжид буй.

Шашинд орохын үүд итгэлийн хөтөлбөрийн сэтгэлгэ сайн хувьтны эрэл хангагч хэмээх судар ориш. Модон бар. 10x55 см. 34 хуудас (хуудасны хоёр тал). Шинжааны Илийн Хасаг үндэстний өөртөө засах жэугийн Монголхүрээ сянийн Шат киргиз үндэстний сумын Очир Намжилын хадгаламжид буй. 33b-34a.

Лувсанбалдан Х. Тод үсэг, түүний дурсгалууд. Уб. 1975.

Мянгад Эрдэмт. Дундад улсад хадгалагдаж байгаа тод үсгийн барын номын тухай дахин өгүүлэх нь (1742-1949). Дундад улсын монгол судлал. 2011, 6 дугаар хугацаа; 中国にあるトド文字版モンゴル文献について《早稲田大学モンゴル研究》、2009年第5号。

Мянгад Эрдэмт. Дундад улсад хадгалагдаж байгаа тод үсгийн барын ном. Өвөр Монголын нийгмийн шинжлэх ухаан. 2005, 4 дүгээр хугацаа.

钦定西域同文志, 吉林出版集团有限责任公司, 年, 第. 2005.

约·巴德利. 俄国·蒙古·中国, 商务印书馆, 1981年.